

Агуулга

БҮЛЭГ 1. Төслийн танилцуулга	2
БҮЛЭГ 2. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	5
БҮЛЭГ 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	7
БҮЛЭГ 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	10
БҮЛЭГ 5. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	11
БҮЛЭГ 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	13
БҮЛЭГ 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	15
БҮЛЭГ 8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	18
БҮЛЭГ 9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	20
БҮЛЭГ 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв	21
Хүснэгт 1.Уурхайн ажиллах горим.....	4
Хүснэгт 2.Уурхайн ажиллах горим.....	4
Хүснэгт 5.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	8
Хүснэгт 6.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	10
Хүснэгт 7.Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	12
Хүснэгт 8.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	14
Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	16
Хүснэгт 10.Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	19
Хүснэгт 11.Талуудад тайлагнах хуваарь	20
Зураг 1.Төслийн байршил.....	3

БҮЛЭГ 1. Төслийн танилцуулга

Төсөл хэрэгжүүлэгч: “Өвөрголд” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011472114

Регистрийн дугаар: 5824699

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-021413

Төслийн байршил: Тус орд нь засаг захиргааны хувьд Хэнтий аймгийн Дархан, Бор-өндөр сумдын нутагт байрлах ба номенклатурын L-49-63-р хавтгайд Монгол орны зүүн хэсэгт, Бор-Өндөр сумын төвөөс баруун урагш 10 км, Улаанбаатар хотоос зүүн урагшаа 330 км зайд оршдог.

Үйл ажиллагааны хүрээ

“Өвөрголд” ХХК -ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дархан сумын нутагт орших Адагийн хайлуур жоншны ордын баруун урд үргэлжлэл хэсгийн ордыг далд уурхайн аргаар ашиглах төслийн үйл ажиллагааны явцад мөрдөж ажиллах Байгаль орчны холбогдолтой Монгол улсын хуулиуд, төсөлтэй холбоотой стандартууд, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенци, тэдгээртэй адилтгах эрхзүйн баримт бичгүүдийн холбогдох заалтууд зэргийг хамтад нь тусгав.

Төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчныг хамгаалах чиглэлээр дагаж мөрдвөл зохих хууль тогтоомжууд, дүрэм, журам, стандартуудын жагсаалтыг дор дурдлаа. Үүнд:

Хууль тогтоомжууд Байгаль орчныг хамгаалах тухай хууль,

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль,

Газрын тухай хууль,

Газрын хэвлийн тухай хууль,

Ашигт малтмалын тухай хууль,

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль

Агаарын тухай хууль,

Байгалийн ургамлын тухай хууль,

Ургамал хамгааллын тухай хууль,


Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль,

Соёлын өвийг хамгаалах тухай хууль

Хог хаягдлын тухай хууль,

Эрүүл мэндийн тухай хууль

Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дархан сумдын нутагт орших MV-021413 тоот ашиглалтын тусгай зөвшрөөлийн талбайд орших “Адаг” нэртэй хайлуур жоншны уурхайн баруун урд үргэлжлэл хэсгийг далд аргаар ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг 1.Төслийн байршил

Ордын уул-техникийн нөхцөл: Хүдрийн биет нь газрын гадаргууд ил гараагүй суналын дагуу 500-600 м орчим урттай, газрын гадаргаас 20-200 м гүнд орших бөгөөд кварц-флюоритын найрлагатай жоншны судлын зузаан нь ордын хэмжээнд дундажаар 3.75м, хүдэр дэх флюоритын дундаж агуулга нь 31.06% CaF_2 байна. Орд нь газрын гадаргуугийн хувьд далайн түвшнээс дээш 1420-1450 м өргөгдсөн хөндий хоолой, ухаа гүвээ, нам толгод зонхилно. Хүдэр болон агуулагч чулуулгийн бат бөх дунджаар $f=9$ байна. Хүдэр болон чулуулгийн эзлэхүүн жин дунджаар 2.6 м³ /тн байна. Ордын ТЭЗҮ 2026 оны 6-р сард батлагдсан бөгөөд 2026 оны уулын ажлаар босоо 2 гол ам, агааржуулалтын туслах ам нэвтрэлтийн ажлыг эхлүүлж, I-C-10 блок хүртэл олборлолт хийж энэ жилдээ 50 мян.тн жонш олборлохоор төлөвлөсөн.

Уурхайн ажлын горим, календарь төлөвлөлт: Уурхайн ажлын горим. Уурхай нь 2023 онд 6-р сараас 15 эхлэн бэлтгэл ажлыг хангаж 2-12 сарыг дуустал бүтэн ажиллахаар төлөвлөв. Хоногт 2 ээлжтэй, ээлжийн үргэлжлэх хугацаа 7 цаг байна. Энэ хугацаанд Босоо гол ам болон агааржуулалтын туслах ам нэвтрэлтийг үргэлжлүүлж, олборлолтын ажил хийхээр төлөвлөв.

Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дархан сумдын нутагт орших MV-021413 тоот ашиглалтын тусгай зөвшрөөлийн талбайд орших “Адаг” нэртэй хайлуур жоншны уурхайн баруун урд үргэжлэл хэсгийг далд аргаар ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 1. Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээс	Тайлбар
1	Жилийн ажлын горим	Тасралтгүй		
2	Жилийн календарь хугацаа	Хоног	365	
3	Жилд ногдох ажлын бус хоног	Хоног	10	Баяр ёслол, цаг агаар, засвар үйлчилгээ
4	Жилд ажиллах хоног	Хоног	240	-
5	Хоногийн ажлын горим	Ээлж	3	-
6	Ээлжийн хугацаа	Цаг	7	-
7	Хоногт ногдох ажлын нийт цаг	Цаг	21	-
8	Жилд ногдох ажлын нийт цаг	цаг	5040	-

Календарь төлөвлөлт. Уулын ажлын хүчин чадал, ажиллах горимтой уялдуулж дараах календарь төлөвлөгөөг тооцоолов. Ордоос 2026 онд нийт 32,3 мян.м³ уулын цул хөдөлгөх бөгөөд нийт малталтаас 13,08 мян.м³ хоосон чулуулаг гаргаж, 50 мян.тн хайлуур жоншны хүдэр облолохоор төлөвлөв.

Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2021 онд				Уулын ажлын нийт хэмжээ
			I-р улирал	II-р улирал	III-р улирал	IV-р улирал	
1	Уулын цул	мян.м ³	7.1	7.5	7.5	5.3	27.4
2	Малталаас гарах хоосон чулуулаг	мян.тн	12	7.5	7.5	3.72	31.12
		мян.м ³	4.8	2.88	2.88	1.43	11.97
3	Хүдэр олборлолт	мян.тн	6.0	12.0	12.0	10.0	40.0
		мян.м ³	2.3	4.6	4.6	3.8	15.4
4	Дундаж агуулга, CaF ₂	%	29.12	29.12	29.12	29.12	29.12
5	Жоншны нөөц	мян.тн	1.75	3.49	3.49	2.91	11.65
6	Хайлууржоншны баяжмал	мян.тн	1.79	3.58	3.58	2.98	11.93

БҮЛЭГ 2. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

Төсөл хэрэгжих орчны тухай: Багануур-Чойрын зүүн бүсийн 110 кв-ын өндөр хүчдэлийн сүлжээнд холбогдсоны дээр МЦХК, Мобиком, Скайтелийн үүрэн телефоны компаниуд үйл ажиллагаа явуулж, интернэтийн 24 цагийн үйлчилгээ нэвтэрсэн.

Бор-Өндөр сум нь хүн амын тоогоор Хэнтий аймгийн 18-н сумаас 1-рт ордог. Тус суманд Халх, Казах, Дөрвөд, Буриад, Торгууд, Урианхай, Дарьганга, Үзэмчин зэрэг олон ястан үндэстэн амьдардаг. Хүн амын нягтралаар хамгийн өндөр 60.99 хүн/га сум юм. Газар нутгийн нийт хэмжээ 14000 га. Үүнээс Уул уурхай 9500га буюу 67.8 хувь, Тосгон, суурингийн газар 3000га буюу 21.5 хувь Дэд бүтэцийн барилга байгууламж бүхий газар 1500га буюу 10.7 хувь тус тус эзэлж байна.

Уул зүй: Энэ нутаг нь газар зүйн бүсийн ангиллаар хээр талын бүсэд хамрагдана. Тус нутагт өндөр уул нуруу, гол мөрөн байхгүй. Газрын гадаргуу нь жижиг гүвээ, толгод, тэгшивтэр тал гадаргаас бүрдэнэ. Талбайн төв хэсгээр жижиг гүвээ, толгодууд орших ба тэдгээр нь сулавтар хэрчигдэлтэй, жижиг гуу жалгуудтай. Харин талбайн баруун хойт ба зүүн өмнөт хэсгээр томоохон хөндий, талууд оршино. Талбайн хэсэгт орших хамгийн өндөр цэг нь далайн түвшинөөс дээш 1550 м-т өргөгдсөн ба хамгийн нам дор цэг нь 1200м-ийн у...улс хоорондын жижиг хөндий болно. Толгодын харьцангуй өндөр 40-70м-т хэлбэлзэнэ. Судалгааны талбайд ой мод, намаг шавар байхгүй.

Уур амьсгал: Судалгааны талбай нь жилийн дөрвөн улирал ээлжлэн солигддог эх газрын эрс тэс уур амьсгалтай. Улирлын температурын зөрүү их. Өвөл нь -37.5С хэм хүртэл хүйтэрнэ. Зун хамгийн их халж +34.9-өөс +40С хэм хүрнэ. Жилд унах хур тунадасны хэмжээ дунджаар 277 мм бөгөөд үүний 70 гаруй хувь нь зуны улиралд бууна. Жил бүрийн 10-р сарын сүүл үеэс цас орж хүйтний улирал эхэлдэг. Салхины хурд 3-5 м/сек-ээс 18 м/сек хүрнэ. Заримдаа түүнээс ч хүчтэй шороон шуурга шуурна.

Ургамал амьтан: Энэ нутагт нугын бутлаг ургамал ургах ба тал хээрийн жижиг мэрэгч болон цагаан зээр, аргал янгир болон жигүүртэн амьтад амьдардаг.

Ургамал: Тус сумын нутаг ботаник газар зүйн мужлалаар дээгүүр, Монголын хээрийн тойргийн Нялгын районд хамаарна. Уулын хээрт: Цахилдаг, алаг өвст, хиаг-хялганат, бужмаг, хонгорзул, улалж, бут бударгана, харгана, халгай, буурцагт өвсний төрөл зонхилно. Тал хээрт: Үетэн хялганат, хазаар өвс, хиаг-хялганат, шарилж, лууль, дэрс болон амт чанар, шимт сайтай үетэн, буурцагт, алаг өвсний төрлийн ургамал зонхилно. Мөн гол, булаг, нуур тойрмын хөвөөгөөр хиаг, хазаар өвс, салхин ерхөг, дэрс, харгана, адамсын агь, хэрс зэрэг ургамал ургадаг ба сумын урд говирхог талаараа таана, мангир, хөмүүл, ерхөг, үетэн хялганат, алаг өвс, жижиг бутан үетэн, ботуульт ургамал зонхилон ургадаг байна.

Сумын нийт бэлчээрийн 4.5 хувь нь цэвэр бэлчээр, 59 хувь нь сөөгт бэлчээр, 22 хувь нь чулуурхаг бэлчээр, 14,5 хувь нь довонтой бэлчээр байна. Эмийн ургамлаас: Юлдэн тарваган шийр, өргөст сарнай, нохойн хошуу, говийн ганга, таван салаа, царван, хөх дэгд, шар дэгд, цөс өвс, арц, банздоо, бошго, сөд, соргол зэрэг олон зүйлийн эмийн ургамал ургадаг.

Агнуурын ан амьтан: Чоно, үнэг, хярс, бор туулай, дорго, хүрнэ, мануул, цагаан зээр, тарвага зэрэг ан амьтан элбэг тааралдах ба сүүлийн жилүүдэд байгалийн хувьсан өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас тарвага, цагаан зээр зэрэг агнуурын ан амьтад эрс ховордсон байна. Жигүүртэн шувуу: Махчин шувууд: Энэ төрлийн шувуудаас Дархан сумын нутаг дэвсгэрт бүх төрлийн бүргэд, шилийн сар, идлэг шонхор, начин шонхор, зээрд шонхор, тас, элээ, шар шувуу зэрэг.

БҮЛЭГ 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Энэхүү бүлэгт 2026 онд уурхайн олборлолтоос байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг урьдчилан судалж тэдгээрийг бууруулах арга хэмжээний зөвөлгөө боловсруулав.

Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дархан сумдын нутагт орших MV-021413 тоот ашиглалтын тусгай зөвшрөөлийн талбайд орших “Адаг” нэртэй хайлуур
жоншны уурхайн баруун урд үргэжлэл хэсгийг далд аргаар ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 3.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар орчин									
1	Уурхайн ажилчдын хотхоноос уурхайн налуу ам хүртэл уурхайн ажилчид машинтай зорчих үед тоосжилт үүсэх	Хур борооны усыг хуримтлуулан зам талбайг услах	Уурхайн олборлолтын үед	м ²	1 м ² талбайг 2л усаар	1	300 000	Тоосжилттой үед	MNS 4585:2016 MNS 3384-82 MNS 12.055- 9
2	Ажилчдын машинуудаас ялгарах утаа, тортог нь агаар орчинг бохирдуулна.	Ажилчдын машиныг тогтмол үзлэг оншилгоонд оруулж байх.	Ажилчдын машин	ширхэг	250 000	2	200 000	Цаг тухайд нь	
Хөрсөн бүрхэвч									
3	Уурхайн эргэн тойрны тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихтэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн, доройтох, талхлагдах,	ОХШХ-н хүрээнд хөрснөөс дээж авч шинжлүүлэх. Олон салаа зам гаргахаас сэргийлэх	Уурхайд ашиглах машин, механизмудад	ширхэг	-	2	500 000	3, 7, 11, сарууд	MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
4	Уурхайн тэсэлгээнээс үүдэн газрын хэвлий эвдрэлд орох	Хөрснөөс дээж авч лабораторид шинжлүүлэх	Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд	мян.м ³	20 000	2	3, 7, 11, сарууд		
Усан орчин									
	Ахуйн болон шатах тослох материалын хаягдал Хүмүүсийн анхаарал хайхрамжгүйн улмаас асгарах, гоожих Хөрс болон хөрсний ус бохирдох магадлалтай.	Уурхай орчмын гүний усны худагнаас дээж авч шинжлүүлэх	Гүний ус	м ³	-	1	1 000 000	6 болон 9н сард	MNS 900:2018 MNS 4943:2015

Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дархан сумдын нутагт орших MV-021413 тоот ашиглалтын тусгай зөвшрөөлийн талбайд орших “Адаг” нэртэй хайлуур
жоншны уурхайн баруун урд үргэжлэл хэсгийг далд аргаар ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	Хур борооны усаар угаагдаж хөрсний ус бохирдуулна.								
Амьтны аймаг, ургамлан нөмрөг									
5	Олон хүний хөл хөдөлгөөн, машин техникийн холхилтоос ургамлан бүрхэвч талхагдана.	Тогтсон нэг маршрутаар ажилчдыг зорчуулах, ан амьтан агнахгүй байх	Уурхайн тусгай зөвшөөр лийн талбайн ойр орчимд	га	MV- 021413	-	1 000 000	3, 7, 11, сарууд	-
						3 000 000			

БҮЛЭГ 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Энэхүү бүлэгт 2026 онд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд хийгдэх техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн хуваарийг оруулав. Мөн “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний хүрээнд орон нутгаас 5000 ширхэг шар хуйас мод тарихыг үүрэг болгосон

Хүснэгт 4.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба дамтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Дүйцүүлэн хамгаалах Техникийн нөхөн сэргээлт	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд аймгийн Бор өндөр сумын Байгаль орчны газраас нийт 2.5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө авсан. Тэр бум мод аяны хүрээнд 2000 модны суулгац авхар төлөвлөв	га	2.5 га		4000 000	9 дугаар сард	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал
2	Биологийн нөхөн сэргээлт					5000 000		
						9 000 000		

БҮЛЭГ 5. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Байгалийн аюул, гамшиг

Аянга цахилгаан. Дулааны улиралд тохиолдох бөгөөд цаг агаарын мэдээг тогтмол мэдээллэх хэрэгтэй. Цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг стандартын дагуу газардуулсан байх, ил задгай цахилгааны утас зэрэг аянга үүсч болзошгүй зүйлсүүдийг хамгаалах

Газар хөдлөлт: Газар хөдлөлтийн мужлалаар төсөл хэрэгжих газар нь 6 баллын бүсэд хамаарна. Иймээс барилга байгууламж барихдаа зураг төслийн дагуу эрсдлийг нарийвчилан авч үзэх шаардлагатай. Мөн ашиглалтын явцад газар хөдлөлтийн үед авах арга хэмжээг боловсруулах. Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгох. Уурхайн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бий болгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөх.

Шороон шуурга: Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгох. Уурхайн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бий болгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөх. Халдварт өвчин: Уурхайн ажилчдад хууль бус ан агнахгүй байх түүнээс үүдэн гарах сөрөг нөлөөллийн талаар сургалт явуулах, хамгаалалтын хэрэгслээр хангах (амны хаалт г.м), аймгийн эрүүл мэндийн төвтэй харилцаа холбоотой байж мэдээлэл авч байх

Гал түймэр: Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, зааварчилгаа, хяналтын ажил, гал гарсан үед түүнийг унтраах хэрэгслийн хангамж, цахилгаан тоног төхөөрөмждээр ажиллах үд мөрдөх аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга хэмжээг МУ-н “Талын аюулгүй байдлын тухай хууль”, “Аж ахуй нэгж байгууллагад дагааж мөрдөх галын аюулгүй байдлын дүрэм”, “Гал түймрийн аюулгүй байдалтай холбогдуулан гаргасан тушаал, шийдвэрийн дагуу зохион явуулна

Авто тээврийн осол: Машин техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх, ажлын байрны үзлэг шалгалтыг байнга хийх. Ажилчидын аюулгүй ажиллагааны сургалтанд тогтмол хамруулах. Уурхайн зам тээвэрт хурдны хязгаар тогтоож, тэмдэг тэмдэглэгээг сайн хийх, замын хөдөлгөөний аюулгүй дүрмийг чанд баримтлан ажиллах.

Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дархан сумдын нутагт орших MV-021413 тоот ашиглалтын тусгай зөвшрөөлийн талбайд орших “Адаг” нэртэй хайлуур
жоншны уурхайн баруун урд үргэжлэл хэсгийг далд аргаар ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 5.Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Үйлдвэрийн аваар осол, саатал гэмтэлээс шалтгаалан ажилчид бэртэж гэмтэх, хөдөлмөрийн чадвараа алдах эрсдэлтэй,	Уурхайн ган татлаг тороосыг шинжилгээнд өгч шинжлүүлэх	Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд	-	-	500 000	3р сар	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль
	Нийт					500 000		

БҮЛЭГ 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслын хаягдал зэргээс бүрдэж байна.

Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах тус бүлэг тусгасан болно. Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дархан сумдын нутагт орших MV-021413 тоот ашиглалтын тусгай зөвшрөөлийн талбайд орших “Адаг” нэртэй хайлуур
жоншны уурхайн баруун урд үргэжлэл хэсгийг далд аргаар ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 6.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хог хаягдал	Уурхайн ажилчдаас гарах хатуу хог хаягдал 696 кг хатуу хог хаягдал гарахаар байна.	Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нэгдсэн хогын цэгт хогоо нийлүүлэх,	кг	-	-	200 000	Хог хаягдлын тухай хууль
		Ахуйн хатуу хог хаягдлаа төрөлжүүлэн ялган ангилах хогийн савнуудыг худалдан авч хог хаягдлын төрлийг хогийн савны гадна бичиж байрлуулна.	Ажилчдын гэр байшингийн гадна байршуулах	тоо	500 000	10	300 000	
2	Үйлдвэрийн хог хаягдал	Уурхайд ашиглаж буй машинаас гарсан дугуй, хатуу хог хаягдлыг тусгай эрхтэй гэрээт компанид өгч устгуулах	Уурхайд ашиглагдаж буй машин болон бусад зүйлс	тоо	1 000 000	-	1 000 000	
3	Аюултай хог хаягдал.	Машинаас гарсан хаягдал, тос масло болон бусад аюултай бодисууд Тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий компанид нийлүүлэх	Тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий компанид нийлүүлэх	тн	1000 000	-	500 000	
				2 500 000				

БҮЛЭГ 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсонболзошгүй сөрөг нөлөөллийг тодорхой хугацааны давтамжтай хянах, тайлагнах, бууруулах, арилгах арга хэмжээ авахад тус хөтөлбөрийн зорилго оршино.

Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах болон төслийн үйл ажиллагаанд дараах үндсэн ач холбогдолтой. Үүнд:

- ✓ Байнгын хяналт шинжилгээ хийснээр төслөөс орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тухай бүрт эрт илрүүлэх
- ✓ Тухайн илрүүлсэн сөрөг нөлөөллийг үндэслэн тодорхой цаг хугацааны дотор байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах
- ✓ Хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хийлгэн төр захиргааны байгууллагууд болон төсөл хэрэгжих орон нутгийн оршин суугч, иргэдэд танилцуулж байх нь төслийн цаашид тогтмол хэрэгжих нөхцлийг бүрдүүлэх юм.

“Өвөрголд” ХХК-ийн “Адаг” хайлуур жоншны ордын баруун урд үргэлжлэл хэсгийг далд аргаар ашиглах бөгөөд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж буй өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах зорилгоор жил бүр хяналт шинжилгээний ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хэрэгжүүлдэг.

2023 онд хэрэгжүүлэх хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд Агаарын чанарын хяналт шинжилгээ, Гадаргын болон гүний усны хяналт-шинжилгээ, Хөрсний хяналт шинжилгээ, ундны ахуйн усны чанарын хяналт зэргээр явуулахаа төлөвлөгдөж байна. Энэ жилийн хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго байгаль орчинд бохирдол нөлөөлөл байгаа эсэхийг тогтоох, шинжилгээний үр дүн стандартын түвшинд байгааг тогтооход оршино.

Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дархан сумдын нутагт орших MV-021413 тоот ашиглалтын тусгай зөвшрөөлийн талбайд орших “Адаг” нэртэй хайлуур жоншны уурхайн баруун урд үргэжлэл хэсгийг далд аргаар ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаар							
1	Тоос нийт (PM10, PM2.5), CO ₂ , NO ₂ , SO ₂ , H ₂ S	Далд уурхайн агааржуулалтын амны хэсгээс-1 цэг Далд уурхай дотор-1 цэг	6,10 сард	Жилд 2 удаа	Өөрсдийн багажаар PM 2.5 болон PM 10 үзүүлэлтийг үзнэ.	500 000	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар-хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2016
2	Гадаад орчны дуу чимээ, ажлын байрны дуу чимээ	Хамгийн их дуу чимээ ихтэй газар, ажилчдын хотхонд					
Хөрсөн бүрхэвч							
3	Агрохими болон хүнд металлын шинжилгээ	Уурхайн ажилчдын кемп Хог хаягдлын цэг орчим Ажилдчын жорлон Тэсэлгээний агуулахын ойр орчим	6,10 сард	Жилд 2 удаа	Агрохими шинжилгээ 20 000 төгрөг	20 000 * 8 = 160 000	MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр. төрөл MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох MNS2305-94 Дээж авах. савлах. тээвэрлэх. хадгалах журам MNS(ISO) 4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх
Усан орчин							
4	Бактериологи Химийн ерөнхий шинжилгээ	Унд ахуйн ус Хаягдал ус	6,10 сард	Жилд 2 удаа	Бактериологи – 45 210 Химийн ерөнхий шинжилгээ – 43 000 Хүнд металл – 78 000	45210*2 = 90 420 43000*2 = 86000 78000*1 = 78000 Нийт 254 420	Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус, Ерөнхий шаардлага MNS 4943:2015, Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2018, Байгаль орчны аялал жуучлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018

Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дархан сумдын нутагт орших MV-021413 тоот ашиглалтын тусгай зөвшрөөлийн талбайд орших “Адаг” нэртэй хайлуур
жоншны уурхайн баруун урд үргэжлэл хэсгийг далд аргаар ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

							оны 04 сарын 05 өдрийн А82/128 тоот тушаалын хавсралт. Ахуйн хаягдал ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам
					914 420		

БҮЛЭГ 8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Уурхайн ажиллагсдын удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг дараах байдлаар зохион байгуулагдана. Үүнд:

- Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа бүрийн технологийн заавар, горим, стандарт, аюулгүй ажиллагааны шаардлага, заавар дүрмийг ажиллагсдад эзэмшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах.
- Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг бүрэн хангаж Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хууль, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах үндэсний хөтөлбөр”, “Аж ахуй нэгж байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах дүрэм”, “Ашигт малтмалын ордыг ил аргаар олборлоход мөрдөх аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн заалтуудыг мөрдлөг болгон ажиллах.
- “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, эрх зүйн актууд, тогтоол журам шийдвэр, стандарт шаардлага, зөвлөмжийг судалж баяжуулан мөрдөх.

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдийг цаг тухайд нь авч хэрэгжүүлэх ажлыг доорхи удирдлага зохион байгуулалтын системийн дагуу биелүүлж ажиллах нь чухал гэж үзлээ.

Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дархан сумдын нутагт орших MV-021413 тоот ашиглалтын тусгай зөвшрөөлийн талбайд орших “Адаг” нэртэй хайлуур жоншны уурхайн баруун урд үргэжлэл хэсгийг далд аргаар ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 он				
			Сар ...	Сар ...	Сар ...		
	1	2	3	4	5	6	7
1	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах.	1 000 000	7 сард	-	-	Уурхайн дарга, Байгаль орчны мэргэжилтэн	Үйлдвэрийн осол эрсдлээс урьдчилан сэргийлэх байгаль орчноо хамгаалах үүднээс сургалт зохион байгуулах
2	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон Хэнтий аймгийн БОГ-т хүргүүлэх	-	11 сард			Байгаль орчны мэргэжилтэн	2023 БОМТ биелэлтийн тайланг хийн Төв аймгийн БОГ-т хүргүүлэх
	Нийт	1 000 000					

Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дархан сумдын нутагт орших MV-021413 тоот ашиглалтын тусгай зөвшрөөлийн талбайд орших “Адаг” нэртэй хайлуур жоншны уурхайн баруун урд үргэжлэл хэсгийг далд аргаар ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

БҮЛЭГ 9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 9.Талуудад тайлагнах хуваарь

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Бор-Өндөр сумын нутгийн оршин суугчдад	Пресентацаар	Далд уурхайн үл ажиллагаа	10 сард	1 000 000	Уурхайн дарга	Уурхайн ажилчдын амрах газар
	Нийт				1 000 000		

БҮЛЭГ 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв

№	Зардлын утга	Нийт зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	3 000 000
2	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний зардал	500 000
3	Хог хаягдалын менежментийн төлөвлөгөөний зардал	2 500 000
4	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	914 420
5	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний зардал	1000 000
6	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний зардал	1000 000
7	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	9 000 000
	Нийт	17914520

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд **17 914 520** төгрөг болсон. 2026 онд байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа болгож 8 957 260 төгрөг нөхөн сэргээлтийн дансанд байршуулах хүсэлтэй байна.